



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/369

Мандалговь

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан  
оготготой энгийн механик аргаар  
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, 32.1.10 дахь заалт, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/76 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үлийн цагаан оготготой энгийн механик аргаар тэмцэх ажлыг Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай зэрэг нийт 7 сумын 50,0 мянган га бэлчээрийн талбайд улсын төсвийн хөрөнгөөр 2021 оны 10 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 11 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл 20 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулсугай.

2. Үлийн цагаан оготготой тэмцэх арга хэмжээг батлагдсан төсөвт багтаан Засгийн газрын 185 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн мэргэжлийн анги албад, албан байгууллага, малчид иргэдийг оролцуулан гүйцэтгүүлж, бэлчээрийн талбайд үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготготой энгийн механик аргаар тэмцэх ажлыг зохион байгуулахдаа хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр хангах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдөж ажиллахыг үлийн цагаан оготготой тэмцэх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Сумдын засаг дарга нартай гэрээ байгуулан, тэмцэх талбай болон санхүүжилтийг хуваарилах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гэрээний биелэлтэд хяналт тавих, тайлан мэдээг хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Ажлын явцад хяналт тавьж, илэрсэн дутагдал, зөрчлийг цаг алдалгүй арилгаж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргал-д үүрэг болгосугай.

6. Энгийн механик аргаар тэмцэх ажлыг зохион байгуулахдаа "Ковид-19" цар тахлын халдвараас урьдчилан сэргийлж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллахыг тухайн сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. 2021 онд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготготой энгийн механик аргаар тэмцэх ажилд хамрагдах сумдын нэр, тэмцэх бэлчээрийн талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481 210170

Аймгийн Засаг даргын 2021 оны  
10 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар  
захирамжийн хавсралт

**БЭЛЧЭЭРИЙН ХОРТОН МЭРЭГЧ ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ЭНГИЙН  
МЕХАНИКИЙН АРГААР ТЭМЦЭХ СУМД, ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ**

№	Сумын нэр	Энгийн механик аргаар тэмцэх талбайн хэмжээ /мян га/
1	Адаацаг	9
2	Говь-Угтаал	6
3	Дэрэн	6
4	Дэлгэрцогт	6
5	Сайхан-Овоо	6
6	Цагаандэлгэр	7
7	Эрдэнэдалай	10
	<b>дүн</b>	<b>50</b>